

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
	Үүрэг даалгавар НЭГ: <i>Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/378 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ажлын хэсгийг үнэн, бодитой мэдээ, мэдээллээр хангаж, ил тод, нээлттэй, ажлын уялдаагаа, хангаж, тулгамдсан асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэн ажиллах.</i>			
1	<p>Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 07 дугаар тогтоолоор батлагдсан дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээг байгуулах ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулж явцын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд нийт шинээр хэрэгжүүлэх 7 төсөл арга хэмжээ батлагдсанаас:</p> <ul style="list-style-type: none">➢ Тендерийн шатанд 3➢ Гэрээ байгуулан ажил үргэлжилж буй 3➢ Гэрээ байгуулах шатандаа 1 төсөл арга хэмжээ байна. <p>Он дамжин хэрэгжиж буй 47 төсөл арга хэмжээ батлагдсанаас:</p> <ul style="list-style-type: none">➢ Тендерийн шатандаа 5➢ Гэрээ байгуулан ажил үргэлжилж буй 16➢ Бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн 26 төсөл арга хэмжээ байна. <p>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 24 төсөл арга хэмжээ батлагдсанаас:</p> <ul style="list-style-type: none">➢ Гэрээ байгуулах шатандаа 6➢ Тендерийн шатандаа 18 төсөл арга хэмжээ тус тус байна. <p>Он дамжин хэрэгжих 11 төсөл арга хэмжээ батлагдсанаас:</p> <ul style="list-style-type: none">➢ Гэрээ байгуулсан ажил үргэлжилж буй 2➢ Бүрэн дуусган хүлээлгэн өгсөн 9 төсөл арга хэмжээ байна. <p>Дүүрэгт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 он дамжин хэрэгжих 43 төсөл, арга хэмжээ 146,923.1 сая төгрөгийн байна.</p> <p>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих 1 төсөл арга хэмжээ 300.0 сая төгрөг</p> <p>2022-2023 он дамжин хэрэгжих нийт 10 төсөл арга хэмжээ 39,632.98 сая төгрөг</p> <p>Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжих 1 төсөл арга хэмжээ 1,200.0 сая төгрөг</p>			90

	<p>2022-2023 он дамжих хэрэгжих 4 төсөл арга хэмжээ 865,0 сая төгрөгийн өртөгтэй байна. Улс, нийслэл, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын нийт 59 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаагаас:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Бэлтгэл ажил хийгдэж байгаа 8 төсөл арга хэмжээ: ➢ Тендерийн шатандаа байгаа 9 төсөл арга хэмжээ: ➢ Гэрээ байгуулах шатандаа байгаа 2 арга хэмжээ: ➢ Гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа 20 төсөл арга хэмжээ: <p>Ажил 100 хувь дууссан 20 төсөл арга хэмжээ тус тус байна.</p> <p>“Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх” ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт тавин ажилладаг Нийслэлийн Замын хөгжлийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Барилгын хөгжлийн төвд хамтран ажиллах тухай албан бичиг 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлсэн. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Барилгын хөгжлийн төвөөс 2023 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний явцын талаар мэдээлэл ирүүлсэн бөгөөд удаашралтай байгаа ажлыг эрчимжүүлэхэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Дүүргийн “Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих төв” -ОНӨТҮГ нь“ 2023 оны 04 дүгээр сарын 20-ны байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Дүүргийн 16-р хороо Авто Баазын Барилга 45%-ийн гүйцэтгэлтэй ➢ Дүүргийн 61 дүгээр сургуулийн “Урлаг” заалыг засварлах ажлын зургийн даалгаврын дагуу гүйцэтгэж байна.Зарим ажил гүйцэтгэлийн тэмдэглэгээ дутуу Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг өгөөгүй зөрчлүүдэд анхааруулж ажлын явцын тайлбар, сар өдрийг тэмдэглэн фото зургаар хавсаргах заавар өгсөн. ➢ Дүүргийн 4-р хороо 46 дугаар байрны фасад засварын ажил өнгө гаргалт блокны өрлөгийн ажил болон хөөсний ажил явагдаж байна. ➢ Дүүргийн 5 дугаар хороо 5 дугаар байрны фасад засварын ажил ажлын графикийн дагуу 60%-ийн гүйцэтгэлтэй байна. 			
<p>Үүрэг даалгавар ХОЁР: <i>Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, аж ахуйн нэгж байгууллагуудад барилгын чанар, стандартын хэрэгжилтийг хангуулах зөвлөмж хүргүүлэх.</i></p>				
2	<p>Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж стандарт, норм дүрмийг мөрдүүлэх, арга хэмжээний зохион байгуулалт, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, иргэдийг болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 6 чиглэлээр үзлэг шалгалт зохион байгууллаа.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Дүүргийн хэмжээнд дэх тоглоомын талбай бичил цэцэрлэг ➢ Гэрэлтүүлгийн үзлэг шалгалт ➢ Зам хусаж тэгшлэх ➢ Мод хэлбэржүүлэх ➢ Явган замын ажил хийж гүйцэтгэх зэрэг ажлууд хийгдэж байна. 			70

	<p>Дүүргийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1-24 дүгээр хороодын Засаг дарга нийт 56 албан хаагчид Хотын стандарт, хяналтын газрын дарга С.Төмөрдулам сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.</p> <p>Тус захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон үйл ажиллагааны удирдамж батлах тухай” А/120 дугаар захирамжаар “Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэхэд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах тухай” удирдамж батлагдсаны дагуу 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар, дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран Бишрэлт зочид буудлын хурлын танхимд хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 231 иргэн, аж ахуйн нэгжид худалдаа үйлчилгээний байгууллагын гадна орчны стандарт, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх зөвлөмж, сургалтыг зохион байгуулсан.</p>			
<p>Үүрэг даалгавар ГУРАВ: Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрт ТҮЦ-үүдийг цэгцлэх ажлаа эрчимжүүлж, нийтийн эдэлбэр газарт өдрийн худалдаа эрхлэх байршил, ажлын даалгавраа тодорхойлж, дүүргүүдэд хүргүүлж, ажлаа уялдуулан хамтран ажиллах.</p>				
3	<p>Дүүргийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Газар албадан чөлөөлөх тухай” А/06 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Газар зохион байгуулалтын албатай хамтран 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Мөнгөн завьяа дэлгүүрийн автобусны буудал дээр байршуулсан нийт 6 түргэн үйлчилгээний цэгийг албадан нүүлгэж, газар чөлөөлөлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Газар албадан чөлөөлөх тухай” А/29 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбай, автобусны буудал дээр олноор байршуулсан зөвшөөрөлгүй түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлтийн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай төлөвлөгөө, судалгааг гарган бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>Хот байгуулалт, хөгжлийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр ирүүлсэн “Мэдээлэл хүргүүлэх тухай” 4/754 тоот албан бичгээр “Нийтийн эдэлбэрийн зам, талбай дээр өдрийн худалдаа хийх байршлыг тодорхойлох” үүрэг даалгаврын хүрээнд батлагдсан байршлын Тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгаврыг улирлын чанартай түр худалдаа эрхлэх хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад танилцуулж, дүүргийн Засаг даргын дэргэдэх “Худалдаа, зохицуулах үйлчилгээг зохицуулах Зөвлөл”-ийн хурлаар хэлэлцэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>			70
<p>Үүрэг даалгавар ДӨРӨВ: Дүүргүүдийн нутаг дэвсгэрт хийгдэж байгаа сагсан бөмбөгийн 3х3 талбайн стандарт норм дүрэмд онцгой анхаарч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.</p>				
4	<p>Дүүргийн хэмжээнд 2022-2023 онуудад он дамжин хэрэгжиж буй 3х3 сагсан бөмбөгийн талбайнууд 6 байршилд бүрэн хийгдсэн, 2023 онд 7 байршилд дахин хийж гүйцэтгэхээр</p>			90

	байршлын судалгааг гарган Хот тохижилтын газарт (ОНӨААТҮГ) 3/984 тоот албан бичгээр хүргүүлсэн.			
Үүрэг даалгавар ТАВ: Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” А/309 дүгээр захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах.				
5	<p>Дүүргийн Онцгой байдлын хэлтсээс ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Улсын Онцгой комиссын 2023 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгавар ➢ Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар албан даалгавар, Нийслэлийн Онцгой комиссын 2023 оны 03 дугаар албан даалгавар ➢ Дүүргийн Онцгой комиссын даргын 02 дугаар албан даалгаврыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна. <p>Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/309 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Дүүргийн Онцгой комиссын даргын 2023 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгавар ➢ Дүүргийн Засаг даргын “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” захирамжийг гаргаж хэрэгжилтийг ханган ажиллах хэлтэс, албад руу хүргүүлсэн. <p>Дүүргийн Онцгой байдлын хэлтэс ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлж Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн бэлтгэл ээлжийн 12 алба хаагч, 2 тээврийн хэрэгсэлтэйгээр:</p> <ul style="list-style-type: none"> ➢ 7 дугаар хороо 70 давхрын оршуулгын газар ➢ 17, 23 дугаар хороо Чингэлтэй хайрхан, Зүрх-Уул, Залаатын ам ➢ 19, 24 дүгээр хороо Шадивлан, Яргайт, Жигжид /Моби/, Жигжид /Аранзат/, Жигжид /Гүнт/, Майхан толгой, Санзай, Халзангийн даваа зэрэг зуслангуудад өнжмөл шар өвс болон ой, хээрийн гал түймэр гарах аюулаас урьдчилан сэргийлэх эргүүлийн үүрэг гүйцэтгэлээ. <p>Чөлөөт цагаар ууланд аялал зугаалгаар зорчигч 1240 иргэд, 382 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, 910 ширхэг санамж, сэрэмжлүүлгийн материал тараах ажлыг зохион байгуулан ажиллалаа.</p> <p>Онцгой байдлын хэлтсийн даргын баталсан “Шар өвс ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө”-ний дагуу 04 дүгээр сарын 01, 02, 08, 09, 15, 16-ны өдрийн Бямба, Ням гаригуудад нийт давхардсан тоогоор 54 алба хаагч дүүргийн 23 дугаар хороо Зүрх уул руу алхалт хийж байгаа 684 иргэнд 1248 ширхэг шар өвс, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэж ажиллалаа.</p> <p>“Шар өвс шатахуунтай адил шатна аян”-ны хүрээнд “Би шар өвсөө шатаадаггүй, ой хээрт аялахдаа ил гал гаргадаггүй хариуцлагатай иргэн” чэлленжид уриалж нэгдүүлэн ажиллаж байна. Шар өвс, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг хэлтсийн сайт, пэйжид нийт 28 мэдээллийг түгээж ажилласан.</p>			90

Үүрэг даалгавар ЗУРГАА: Хүүхэд, залуучуудын хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан гэмт хэрэг, зөрчил болон зам, тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын нэгдсэн арга хэмжээг улирал бүр зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.				
6	<p>Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтсийн даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 116/747 дугаартай албан бичгээр өгөгдсөн чиглэлийн хэрэгжилтийг хангах зам, тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг улсын 18, хувийн 5 сургуулиудад 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 06-ны өдрийн хооронд сургууль хариуцсан зохицуулагч, цэцэрлэг хариуцсан цагдаа зохицуулагч нар нийт 3285 хүүхдэд сургалт зохион байгуулан ажилласан.</p> <p>Ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, ослын шалтгаан нөхцөл хор уршгийг арилгах зорилгоор улсын 18, хувийн 5 сургууль, төрийн өмчийн 38 цэцэрлэгт 4 зүйлийн 65 асуулттай эрсдэлийн үнэлгээ хийж, иргэд олон нийтэд таниулах чиглэлээр бэлтгэсэн сэрэмжлүүлэг “Тото лулу” хоёрын адал явдал замын хөдөлгөөний дүрэмтэй танилцсан нь 10 цуврал контент, “Мотоцикл, хамгаалах малгай” контент, зурагт хуудсыг тус тараан өгч ажиллалаа. Эрсдэлийн үнэлгээний мөрөөр 103, 30 дугаар цэцэрлэгүүдийн замын хөдөлгөөн хязгаарлагдмал газарт хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган толь байршуулсан.</p> <p>Дүүргийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсээс Цагдаагийн газартай хамтран “Хүүхэд хамгаалал-2023” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Тус арга хэмжээний хүрээнд Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт хүүхэд орогнож, байрлаж болзошгүй орц хонгил, гудамж талбай, олон нийтийн газар, цахим тоглоомын газар, үзвэр үйлчилгээний газрууд, хүүхдийн тоглоомын газар, томоохон зах худалдааны төв “Хүчит шонхор”, “Нарантуул-2”, “Нарлаг дэнж”, “Цэцэг” төв, “Улсын их дэлгүүр”, “Пийс молл”, “Алтай центр”, “Гандирс”, “Мөнгөн завъяа”, “Компьютер ланд”, “Теди”, “Монтел гар утас худалдааны төв”-үүд, “Орон зай”, “Бөмбөгөр”, “Алтжин Содон бөмбөгөр” худалдааны төвүүдээр өглөө, оройн цагаар эргүүл, хяналт шалгалт хийж ажилласан.</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Зочид буудал”, “Дэн буудал”, караоке, ресторан, түргэн хоолны газар, кофе шоп, цайны газар, баар, паб, авто угаалга, орц хонгил, интернэт цахим тоглоом гэсэн нийт 22 байгууллага, 36 авто угаалгын газар, 17 сүм хийдээр хяналт шалгалтыг хийж ажилласан.</p> <p>“Хүүхэд хамгаалал-2023” арга хэмжээний хүрээнд насанд хүрээгүй хөдөлмөр эрхлэгч-3, хараа хяналтгүй-5, сургууль завсардсан-2, нийт 11 хүүхдийг илрүүлж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэн хяналтад авч нийгмийн хамгааллын бусад үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.</p>			90
Үүрэг даалгавар ДОЛОО: Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг дүүрэг тус бүрд байгуулж, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/243 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгтэй үйл ажиллагаагаа уялдуулж, ажлын явц, үр дүнг 14 хоног тутамд нийслэлийн ажлын хэсэгт танилцуулж ажиллах				
7	Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хүрээнд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зорилгоор дүүргийн хэмжээнд айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хог цуглуулалт, тээвэрлэлтийн үйлчилгээ, бохир ус татан зайлуулах			70

үйлчилгээ, Гудамжны дүрс бичлэгийн техник хэрэгслийн арчилгаа, засвар үйлчилгээг үзүүлэгч хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө, хэрэгжүүлсэн ажлын тайланг 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн мэргэжилтэн Б.Мандухайн manduhai.b@ulaanbaatr.mn цахим хаягаар хүргүүлсэн.			
---	--	--	--

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ГООМАРАЛ
НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Т.ТҮВШИНЖАРГАЛ